



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТЭС

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН НЭГДСЭН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он

Агуулга

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго	2
Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй	2
Гурав. Товч танилцуулга	2
Дөрөв. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	3
4.1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	3
Тав. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ.....	4
5.1.Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлт.....	4
Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж	5
Долоо. Хавсралтууд.....	6
7.1. Байгууллагын 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.....	6
7.2. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, нотлох баримтууд.....	6

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ үнэлгээний зорилго нь тус газрын 2025 оны үйл ажиллагааны явцад хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, тухайн онд тавьсан зорилт, хүрэх үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хэрэгжилтийг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, сүүлийн хагас жилийн төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43 болон 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж өгч ажиллалаа.

ГУРАВ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд тулгуурлан 2 үзүүлэлтээр дүгнэв.

2025 оны хагас жилд төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн биелэлт, үр дүнг хүрвэл зохих түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий дүнгээр 95.3 хувь буюу өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.03 хувиар нэмэгдэж 5 оноотой үнэлэгдлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны ерөнхий дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

1	Үзүүлэлт	Хувь	Оноо
	2	3	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Засгийн газрын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	93.3	5 (4.03)
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	97.3	
Ерөнхий үнэлгээ		95.3	

ДӨРӨВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.2.Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 оны хагас жилээр 1 зорилт, 3 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжилтийн явц 93.3 хувьтай “үр дүнтэй” байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2.

Д/д	Бодлогын чиглэл	Зорилтын тоо	Нийт арга хэмжээний тоо	Үүнээс						Хэрэгжилт (хувь)
				100%	90%	70%	50%	30%	0%	
	Засаглалын бодлого	1	3	1	2	-	-	-	-	93.3

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

5.1.Байгууллагын 2025 оны хагас гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт,

шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн сайд 01 дүгээр сарын 05-ны өдөр баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газар нь 2 зорилго, 4 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 2025 оны хагас жилийн байдлаар 97.2 хувьтай, “бүрэн хангалттай” гэж үнэлж байна. (Хүснэгт 3, График 1.)

Хүснэгт 3.

Нийт арга хэмжээ-ний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)				Нийт үнэлгээ (хувиар)
	Бүрэн хангалттай 85-100 хувь	Хангалттай 70-85 хүртэл хувь	Хангалтгүй 0-70 хүртэл хувь	Хугацаа болоогүй	
55	52	2	-	1	97.4

График 1.



Зорилт тус бүрээр ангилан үзвэл “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөж 95 хувь, “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан 11 арга хэмжээ 98.1 хувь, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод 34 арга хэмжээ төлөвлөж 98.4

хувь, “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх” зорилтод тусгагдсан ажлууд 92.5 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 4)

Хүснэгт 4.

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ				Дундаж хувь
			100 хувь	85-100 хүртэл хувь	70-85 хүртэл хувь	0-70 хүртэл хувь	
1	2	3	4	5	6	8	9
1	Зорилт 1.Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	2	1	1	-	-	95
2	Зорилт 2.Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	11	9	2	-	-	98.1
3	Зорилт 3.Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	34	28	5	-	-	98.4
4	Зорилт 4.Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ	8	6	-	2	-	92.5
Хугацаа болоогүй-1							
	Нийт	55	44	8	2	-	96

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Байгууллагын 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны үр дүнд явцын хяналт-шинжилгээ хийж, дүнг “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-д заасан аргачлалаар тооцож үнэлэхэд ерөнхий дүн 95.3 хувь, 5 оноотой дүгнэгдсэн нь өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 4.03 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Иймд байгууллага нь арга хэмжээний төлөвлөлт, шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх хугацааг тодорхой төлөвлөн тусгаж, “бүрэн хангалттай”, “хангалттай” хэдий ч зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтдээ бүрэн хүрээгүй арга хэмжээг байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр үр дүнг бууруулахгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан, арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

--oo0oo--